

**АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ
“ХОРШООЛСОН ХЭЛБЭРЭЭР НОГООНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭХ ЗАМААР ӨРХИЙН
АМЬЖИРГААГ САЙЖРУУЛАХ” ТӨСЛИЙН 2020 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл, Монгол улсын засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдөр буцалтгүй тусламжаар хэрэгжих төслийн гэрээнд гарын үсэг зурсан. Уг төсөл Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого, “Хүнсний ногоо” Үндэсний хөтөлбөрийн зорилттой уялдаатайгаар хэрэгжих бөгөөд төслийн үндсэн зорилго нь хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг бэхжүүлэх, хүнсний ногоо тариалагч иргэн, хуулийн этгээдийг дэмжиж хүнсний ногооны ажлыг механикжуулах, дуслын усалгааны технологи нэвтрүүлэх, механикжсан зоорь, өвөл, зуны хүлэмжийн тоо хэмжээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэл, хүнсний ногооны тариалалтыг дэмжиж ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад оршино.
2.	Санхүүжилтийн үүсвэр эх	Буцалтгүй тусламж
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:
	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг бэхжүүлэх, хүнсний ногоо тариалагч иргэн, хуулийн этгээдийг дэмжиж хүнсний ногооны ажлыг механикжуулах, дуслын усалгааны технологи нэвтрүүлэх, механикжсан зоорь, өвөл, зуны хүлэмжийн тоо хэмжээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэл, хүнсний ногооны тариалалтыг дэмжиж ажилгүйдэл, ядуурлыг бууруулах зорилготой.
5.	Зардал	Төсөв Үүнд:
	Нийт	3 сая ам доллар Төсөв, сая төгрөгөөр (2020 он) Гүйцэтгэл, сая Хувь 4,125.9 2,319.4 44.2%
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	
	Бүрэлдэхүүн хэсэг-1	Үнэлгээний тайлангийн 10 дугаар хуудаснаас харна уу.
	Бүрэлдэхүүн хэсэг-2	Үнэлгээний тайлангийн 11 дүгээр хуудаснаас харна уу.
	Бүрэлдэхүүн хэсэг-3	Үнэлгээний тайлангийн 11-13 дугаар хуудаснаас харна уу.
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Төслийн гүйцэтгэлд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээний хийхэд 70.0 хувьтай биелсэн байна. Үнэлгээг бүрэлдэхүүн хэсгүүдийн үйл ажиллагааны хэрэгжилт, төслийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтүүдийн дундаж үнэлгээгээр тооцсон. Төслийн хүрээнд дараах үр дүнгүүд гарсан байна. Үүнд

		<ol style="list-style-type: none"> 1. Тайлант хугацаанд худалдан авах ажиллагаанууд бүрэн хийгдээгүй, төслийн удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалан худалдан авалтууд удааширсан. Нийт зарцуулах төсвийн 44.2 хувийг зарцуулсан байна. 2. Төслийн удирдлага, албан хаагчид тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаа нь төслийн үр дүнд сөргөөр нөлөөлж, үйл ажиллагаа доголдох нөхцөлийг бүрдүүлж байна. 3. Жилийн эцсийн тайлан боловсруулж ХХААХҮЯ-нд ирүүлээгүй нь төслийн хэрэгжилтийг бодитоор тооцох, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ихээхэн хүндрэл учрууллаа. <p>ЗӨВЛӨМЖ</p> <p>Төслийн үр дүнг дээшлүүлэх чиглэлд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Төслийн үлдсэн хугацаанд бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн зорилтыг биелүүлэхийн тулд шалгуур үзүүлэлтийн дагуу төлөвлөлтийг сайжруулан, үйл ажиллагааг эрчимжүүлж улирал, сараар төлөвлөгөө гаргаж ажиллахыг 2. ТХН-ийн хэрэгжүүлэх хяналт үнэлгээний төлөвлөгөөг боловсруулж, төслийн захирлаар батлуулах, төслийн хяналт, үнэлгээний суурь тайлан гаргахыг; 3. Төсөл хэрэгжих нэгжээс зорилтот 4 суманд олгосон трактор, тоног төхөөрөмжийг данс, бүртгэлд бүртгэх, ашиглагчтай эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулахыг; 4. Тогтвортой байдлыг хангах зорилгоор төслийн үр шим хүртэгчдийн байгуулсан хоршоодыг бэхжүүлэх, үүнд хоршооны үйл ажиллагааны зардалд зориулж төслөөс олгох санхүүжилтийг даруй олгож, хоршооны гишүүдийн идэвх оролцоог дэмжих, өдөр тутмын үйл ажиллагаа идэвхтэй явуулах нөхцөлийг бүрдүүлэхийг; 5. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нэмүү өртөг шингээх замаар борлуулалтаас олох орлогыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллахыг, 6. Сургалтын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалтад хамрагдагсад сурсан туршлагаа хэрхэн үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байдалд хяналт тавьж ажиллах, үр дүнг тайландаа тусгах тал дээр анхаарахыг, 7. Тайлангийн чанарыг сайжруулах чиглэлд анхаарахыг тус тус зөвлөмж болгож байна.
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийн тайлант хугацаанд төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж АХБ-нд хүргүүлсэн. АХБ-ны төслийн ахлагч Ян Хинрих Монгол улсад 12-р сард нэмэлт санхүүжилтийн гэрээний хүрээнд 13-14-ний өдрүүдэд АХБ-ны Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт ажиллаж төслийн нэмэлт санхүүжилтийн гэрээний хэлэлцээрийг 2019 оны 12-р сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Уг хэлэлцээрийн үеэр 500,000 ам.долларын нэмэлт санхүүжилтийг өндөр технологит, дөрвөн улирлын хүлэмжийг барих зорилттой ба төслийн нэмэлт санхүүжилтийн үйл ажиллагааг 2020 оны 3-р сараас хэрэгжүүлэхээр АХБ, ХХААХҮЯ, СЯ хэлэлцэж,

			харилцан ойлголцлын санамж бичиг, төслийн баримт бичигт нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэн, баталгаажуулсан.			
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэл т дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		70.0 %	3	70.0 %	70.0 %	70.0 %
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	нэгдсэн	Нэгдсэн үнэлгээ			

1. ХУРААНГУЙ	5
2. ТӨСӨЛД ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ҮНДЭСЛЭЛ.....	5
3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ	5
3.1. Өнөөгийн хэрэгцээтэй тохирч буй байдал буюу хамааралтай байдал	5
3.2. Төслийн хүлээгдэж буй үр нөлөө	5
3.3. Төслийн зорилтын биелж буй байдал буюу үр дүнтэй байдал	5
3.4. Үр дагаварт хүрч буй байдал	6
3.5. Үйл ажиллагааны хэрэгжилт	8
4. ТӨСЛИЙН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ, ТААМАГЛАЛ БА ЭРСДЭЛ ҮҮСЭХ МАГАДЛАЛ, ТЭДГЭЭРИЙН ТӨСӨЛД	12
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	12
5. НИЙЦТЭЙ БАЙДАЛ БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ.....	13
5.1. Стратегийн зорилготой нийцтэй байдал.....	13
5.2. Бодлогын орчин.....	13
5.3. Эдийн засаг, санхүүгийн үндэслэл.....	13
5.4. Институтцийн хүчин чадал.....	14
5.5. Нийгэм-соёлын асуудал.....	14
5.6. Оролцоо ба өмчлөл	14
5.7. Жендер.....	14
5.8. Байгаль орчин	15
5.9. Тохиромжит технологи	15
6. ХЭРЭГЖИЛТИЙН ҮР АШГИЙН ҮНЭЛГЭЭ	15

1. ХУРААНГУЙ

“Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах” төсөл 2018 оны 10 сараас 2021 оны 12 сар хүртэл АХБ-ны ЯБЯС-ийн санхүүжилтээр Дархан-Уул (Орхон), Сэлэнгэ (Ерөө), Төв (Борнуур), Увс (Улаангом) аймгийн 4 суманд хэрэгжиж байна. Төслийн санхүүжилт 3,0 сая ам. доллар.

ХХААХҮЯ-ны дор ТХН, түүнд дэмжлэг үзүүлэн “Хөдөөгийн хөгжилт туслалцааны нийгэмлэг” ТББ ажиллаж, төслийг хэрэгжүүлж байна. ТХН-д төслийн зохицуулагч, санхүүч, худалдан авалтын ажилтан, офисын менежер, жолооч бүтэн цагаар, ХШҮ-ний мэргэжилтэн, өндөр технологийн хүлэмжийн мэргэжилтэн тодорхой сараар, бусад мэргэжилтнүүд “ХХТН” ТББ-ын хүрээнд ажиллаж байна.

2. ТӨСӨЛД ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ҮНДЭСЛЭЛ

Төслийн төлөвлөлт, төсөвд дараах өөрчлөлт оруулах санал гаргаж байна. Үүнд:

- Зарцуулагдаагүй байгаа төсвийг үр шим хүртэгчдэд бодит хөрөнгө оруулалт болгон олгох.
- Түүнтэй уялдуулан 2021 оны ажлын төлөвлөгөө болон сургалтын төлөвлөгөөг бэлтгэх.

3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

Төслийн хүрээнд 2 үр нөлөө, 1 үр дагавар, 3 үр дүнд хүрэх 16 үндсэн үйл ажиллагаа төлөвлөгдсөн.

3.1. Өнөөгийн хэрэгцээтэй тохирч буй байдал буюу хамааралтай байдал

Төслийг ХХААХҮЯ-аас хүнсний ногооны салбарын өнөөгийн хэрэгцээнд үндэслэн, орон нутгийн ногоочид, хамтран ажиллаж, амьжиргаагаа сайжруулах шаардлага, байгаль орчин, жендер зэрэг олон талыг харгалзан үзэж боловсруулсан бөгөөд төслийн хэрэгжилт төслийн баримт бичигт заасны дагуу явагдаж байна.

3.2. Төслийн хүлээгдэж буй үр нөлөө

Төслөөс хүлээгдэж буй 2 үр нөлөө нь:

- I) ТӨСӨЛ хэрэгжсэн газруудад хүнсний ногоо үйлдвэрлэгч жижиг фермерүүдийн амьжиргаа дээшилнэ.
- II) Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах, дасан зохицох чадавх нэмэгдэнэ.

3.3. Төслийн зорилтын биелж буй байдал буюу үр дүнтэй байдал

Төслийн зорилго нь: Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх загвар бий болно.

Энэ зорилгоор төсөл хэрэгжиж дуусахад буюу 2022 он гэхэд

- I) төслөөс гарсан хамтарсан аж ахуй эрхлэх загварыг ХХААХҮЯ цаашид өргөжүүлэх, хуулбарлан хэрэгжүүлэхээр хүлээн авсан байна,
- II) төслийн үр шим хүртэгч жижиг фермерүүдийн хүнсний ногооны тариалалтаас олох орлого 30 хувиар нэмэгдсэн байна (эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдийн хувьд 35%).

Эхний шалгуур үзүүлэлтийн хүрээнд ногоочдын загвар хоршоо байгуулах, түүнийг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Төсөл хэрэгжиж буй 4 суманд 1048 гишүүнтэй 7 хоршоо байгуулагдсан.

Хоёрдох шалгуур үзүүлэлтийн хүрээнд 4 сумын 306 өрхийг нэгтгэсэн 39 ногоочдын бүлгийн 2019 оны хүнсний ногооны борлуулалтын орлогыг (дундажаар 7,5 сая төгрөг/өрх) төслийн

баримт бичигт заасан 2016 оны хэмжээтэй (дундажаар 5,9 сая төгрөг/өрх) харьцуулбал 27,1 хувиар нэмэгдсэн байна.

3.4. Үр дагаварт хүрч буй байдал

Төсөл нь дараах 3 үр дүнд хүрнэ. Үүнд:

Үр дүн 1: Хоршоо хэлбэрээр ажиллах тариаланчдын бүлгүүд байгуулагдана.

Үр дүн 2: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, тогтвортой ногооны аж ахуй эрхлэх технологи, туршлага нэвтэрсэн байна.

Үр дүн 3: Тариаланчид зах зээлд хүрэх боломж нэмэгдсэн байна.

Үр дүн тус бүрийн хүрээнд хүрсэн түвшинг шалгуур үзүүлэлтийн дагуу танилцуулбал:

Үр дүн 1: 1а. Сумын засаг даргад 30 ОНТБ бүртгүүлсэн байна (эдгээрийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэй ахлагчтай байна).

4 сумын 39 ногоочдын бүлэг байгуулагдсан, тэдгээрийн 27 (69,2%) нь эмэгтэй ахлагчтай бүлгүүд байна. Бүлгүүд бизнес төлөвлөгөөгөө боловсруулан, сумын захиргаандаа танилцуулан ажиллаж байна. Мөн 39 бүлгийн тариалангийн талбайн ГМС зураглал гаргаж,

4 сумын газрын даамлаар баталгаажуулан ажиллаж байна.

Сумын нэр	Ногоочдын бүлгийн тоо	Үүнээс эмэгтэй ахлагчтай бүлэг	Бүлгийн гишүүн өрх
Борнуур	10	9	88
Ерөө	10	9	71
Орхон	10	7	70
Улаангом	9	2	77
Нийт	39	27	306

1б. Бүх ОНТБ-ийн хувьд гишүүдийн 50-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна.

39 ногоочдын бүлгийн 1048 гишүүнээс 561 гишүүн нь эмэгтэйчүүд (53,5%) байна.

Сумын нэр	Бүлгийн тоо	Нийт гишүүдийн тоо	Үүнээс эмэгтэй гишүүд
Борнуур	10	348	165
Ерөө	10	224	150
Орхон	10	153	89
Улаангом	9	323	157
Нийт	39	1048	561

Төсөл (“ХХТН” ТББ)-өөс 2019 болон 2020 онд зохион байгуулсан нийт 18 танхимын ба онлайн сургалтанд 1649 эмэгтэйчүүд (нийт 2427 хүн хамрагдсаны 67,9%) хамрагдсан.

1в. Дор хаяж 20 ОНТБ хамтын аж ахуй эрхлэх төлөвлөгөө, дүрмээ боловсруулж, гарын үсэг зурсан байна. 4 сумын 39 бүлэг 2020-2023 онд хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөө бэлтгэх 16 цагийн сургалтад 39 бүлгийн 231 гишүүнийг хамруулсан. Үүний үр дүнд бүлгүүд бизнес төлөвлөгөө бэлтгэн, 2020 онд хоршооны зохион байгуулалтад орж, тариалах талбайгаа 10 хувиар нэмэгдүүлж, 256,9 га талбайд 10 гаруй төрлийн хүнсний ногоо тариалахаар төлөвлөсөн.

Үр дүн 2: 2а. Төслийн үр шим хүртэгч жижиг фермерүүдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 15 хувиар нэмэгдсэн байна.

2019 онд 39 бүлгийн гишүүн 306 өрх нийт 231,2 га талбайд хүнсний ногоо тариалж, 2553,7 тн ургац хураан авч, 2465 тн тн ногоо борлуулан, 2310,8 сая төгрөгийн орлого олсон.

Төслөөс 2019 онд 7 төрлийн таримлын 757,2 кг үр, 2020 онд 7 төрлийн таримлын 1016,0 тн үр, 50 тн бордоо, 456 л ба 240 кг гербицид, пестицидийг хөдөлмөр хамгааллын хэрэглэл, ашиглалтын зааврын хамт нийлүүлсэн.

2020 онд нийт 306,8 га (үүнээс 89,6 га-д төслөөс нийлүүлсэн үрээр) ил талбай, 17,7 га хүлэмжийн талбайд хүнсний ногоо тариалан, 3868 тн болон 72,5 кг ургац хураан авч, урьдчилсан байдлаар 716,5 тн ногоо борлуулж, 633,8 сая төгрөгийн орлого олсон байна.

Энэ нь 2019 онтой харьцуулахад 2020 онд тариалсан талбай 26,5 хувиар, ургацын хэмжээ 36,2 хувиар өссөн үзүүлэлт юм.

2б. Төслөөс туршин ашиглах хүлэмжүүдийн 40-өөс доошгүй хувийг эмэгтэйчүүд эзэмшинэ.

Төслөөс 20 х 6 м хэмжээтэй нийлэг хүлэмжийг 3 сумын 30 бүлэгт тус бүр 1, Улаангом сумын үр үйлдвэрлэгчид болон УГТХ-ийн салбарт олгосон бөгөөд 4 х 8 хэмжээтэй нийлэг хүлэмжийг 4 сумын 39 бүлгийн гишүүн зорилтот 110 өрхөд олгосон, тэдгээрий 90 хувийг эмэгтэйчүүд эзэмшиж байна.

Сумын нэр	Нийт олгосон хүлэмж	Үүнээс 20х6 м хүлэмж	4х8 м хүлэмж
Борнуур	44	14	30
Ерөө	30	10	20
Орхон	37	10	27
Улаангом	49	16	33
Нийт	160	50	110

2в. Хөдөө аж ахуйн сайжруулсан байгууламж, тоног төхөөрөмжийг дор хаяж 180 фермер өрх ашиглана (тэдгээрийн 10-аас доошгүй хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байна).

4 сумын 39 бүлгийн гишүүн 306 өрх төслөөс олгосон 160 хүлэмж, 7 трактор, 20 мотоблок, 5 худгийг хамтарч ашиглан үр шимийг хүртэж байна. Эдгээрийн 55 өрх нь эмэгтэй тэргүүнтэй (17,9%) өрх байна.

2г. Увс аймаг дахь үрийн бүтээгдэхүүний өсөлт одоогийнхоос дор хаяж 50 хувиар нэмэгдэнэ.

	Шар манжин	Шар лууван	Хүрэн манжин	Бөөрөнхий байцаа	Нийт
2019 он	5,1 тн	6,0 тн	2,9 тн	0,1 тн	14,1 тн
2020 он	дүн гараагүй	дүн гараагүй	дүн гараагүй	дүн гараагүй	дүн гараагүй

Үр дүн 3: За. 24 ОНТБ-ийг зах зээл, худалдан авагчидтай холбоно (эдгээрийн 20% нь эмэгтэй ахлагчтай байна).

Энэ чиглэлээр 2021 онд үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.

3б. Төсөл хэрэгжих сумдад бүтээгдэхүүний хорогдол сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 5% буурсан байна.

Үүнийг тодорхойлох үйл ажиллагааг 2021 онд хэрэгжүүлнэ.

3в. Орхон дахь хүнсний ногоо боловсруулах цехийн 45-аас доошгүй хувийг ОНТБ-ийн эмэгтэй гишүүд эзэмшиж байна.

Энэ чиглэлээр 2021 онд үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.

3г. Хүнсний ногооны боловсруулалт, маркетингийн чиглэлээр дор хаяж 144 фермер өрх, 36 үр үйлдвэрлэгч өрхийг сургаж дадлагажуулна (оролцогчын 50-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна)

2019 онд нийт 143 ногоочин өрх, 36 үр үйлдвэрлэгч өрхийг хамруулан 5 сургалт хийсэн.

3д. Харилцан ойлголцлын 2-с цөөнгүй санамж бичигт тариалагч бүлэг болон худалдан авагч гарын үсэг зурсан байна.

Энэ чиглэлээр 2021 онд үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.

3е. Төсөл хэрэгжиж дуусахад 4 сум тус бүрт хүнсний ногооны фермер үйл ажиллагаа эрхлэх дор хаяж 1 аж ахуйн нэгж буюу холбоо байгуулагдсан байна.

Төслийн 4 суманд дараах хоршоод байгуулагдсан ба хоршооны дарга, тэргүүлэгчид болон хяналтын зөвлөлөө байгуулж, дүрмээ батлан, улсын бүртгэлд бүртгүүлэн, банкны данс нээлгэсэн, гишүүдийн хувь оролцоог цуглуулж эхэлсэн.

Дд	Сумын нэр	Хоршооны нэр	Гишүүдийн тоо	Байгуулагдсан он
1	Борнуур	“Бороогийн шим” хоршоо	88	2020
2	Ерөө	“Ерөө ургац” хоршоо	71	2020
3	Орхон	“Орхон шимт ногоон хөрс” хоршоо	28	2020
4		“Газар шим өгөөж” хоршоо	42	2020
5	Улаангом	“Чандмань торгон үр” хоршоо	34	2020
6		“Үрийн өгөөжит гол” хоршоо	21	2020
7		“Комплекс хүлэмжит байц” хоршоо	22	2020
	Нийт		306	

Төсөл болон “ХХТН” ТББ-аас хоршооны тухай сургалт зохион байгуулж, 196 гишүүн (120 эмэгтэйчүүд)-ийг хамруулсан.

Төслөөс нийлүүлсэн 55 морины хүчтэй трактор, анжис, үрлэгч, мөр хооронд хөрс сийрүүлэгч, хүнсний ногоо хураагч агрегатын хамт хоршооны өмчид бүртгэх төлөвлөгөөтэй бөгөөд дундын санд төслөөс нийлүүлэх санхүүжилтийг нийлүүлээгүй байна.

3.5. Үйл ажиллагааны хэрэгжилт

Төслийн хүрээнд нийт 16 үндсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс үр дүн 1-ийн хүрээнд 6, үр дүн 2-ын хүрээнд 4, үр дүн 3-ын хүрээнд 6 үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

Эдгээрээс гадна төслийн менежментийн үйл ажиллагааны хүрээнд ТХН-ийн мэргэжилтнүүдийг шалгаруулж, ТХН байгуулах; жижиг дэд бүтцүүдийн судалгаа, урьдчилсан иж бүрэн судалгааг гүйцэтгэх (18 дахь сар гэхэд); төслийн гүйцэтгэлийн менежментийн тогтолцоог ашиглан төслийн үр нөлөө, үр дагавар, үр дүнд хяналт тавих ба үнэлэх; хагас жилийн явцын тайлангуудыг хүргүүлэх, (2021 он хүртэл); төслийн эхлэлийн (Q2 2018), дунд шатны (Q4 2019) болон эцсийн (Q2 2021) тайлангуудыг боловсруулах ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэж байна.

Ерөнхийдөө үр дүн 1 болон 3, мөн үр дүн 2-ын сургалтын үйл ажиллагааг “ХХТН” ТББ, үр дүн 2 болон төслийн менежментийн үйл ажиллагааг ТХН тус тус хариуцан хэрэгжүүлж байна.

Үйл ажиллагааны хэрэгжилтийн хүрсэн түвшинг 2020 оны III улирлын урьдчилсан байдлаар танилцуулбал:

Үйл ажиллагаа	Хүрсэн түвшин
<p>Үр дүн 1: Хоршоо хэлбэрээр ажиллах тариаланчдын бүлгүүд байгуулагдана.</p> <p>1.1 ОНТБ-ийг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах, аж ахуйн хамтын ажиллагааг яаж явуулах талаар орон нутгийн хүн амын дунд сургалт (үүнд жендэрийн мэдрэмжтэй сургалтууд багтана) явуулах. (Q1 2018)</p>	<p>Дараах сургалтууд хийгдэж, 573 гишүүн (409 эмэгтэйчүүд)-ийг хамруулсан. Үүнд: “Жендер ба манлайлал”, 2019.12</p> <p>“Хоршооны аж ахуй эрхлэх”, 2019.12</p> <p>“Загвар хоршоо байгуулах”, 2020.01</p>
<p>1.2 Тус бүр 5-8 хүнсний ногоо тариалагч өрхүүдээс бүрдсэн 8 тариаланчдын бүлэг болон үр үйлдвэрлэгч 6 бүлгийг төсөл хэрэгжих сум бүрт байгуулах. (Q1 – Q4, 2018)</p>	<p>Нийт 1048 гишүүнтэй 306 өрхийг нэгтгэсэн 39 ногоочдын бүлэг байгуулагдсан. Гишүүдийн 53,5% (561) нь эмэгтэйчүүд, бүлгийн 69,2% (27) нь эмэгтэй ахлагчтай, гишүүн өрхийн 37,9% (116) нь өрх толгойлсон, зорилтот бүлгийн өрхүүд байна.</p>
<p>1.3 Тариаланчдын бүлэгт багтах өрхүүдийн ногооны талбайн байршил, талбайн хэмжээ, тариалдаг ногооны нэр төрөл, аж ахуйн эд хөрөнгө (машин, тоног төхөөрөмж г.м)-ийг бүртгэлжүүлэх, зураг гаргах. (Q1 2018)</p>	<p>“ХХТН” ТББ ногоочдын бүлэгт хамрагдах өрхүүдийн судалгааг хийсэн, тэдгээр нь 1,958,7 га, нийт 234,8 га талбайд 6-аас дээш төрлийн хүнсний ногоо тариалдаг өрхүүд байна.</p>
<p>1.4 Бүлэг бүрт хамаарах (одоо байгаа болоод шинэ) нөөцийн санг тодорхойлж, тэдгээрийг ашиглах, засвар үйлчилгээ хийх, эзэмших, зардал хуваах, захиран зарцуулах дүрэм боловсруулах. (Q2 – Q3, 2018)</p>	<p>4 сумын 39 ногоочдын бүлэг, тэдгээрээс бүрдсэн 7 хоршооны дүрэм, төслийн хөрөнгө оруулалтаар олгосон трактор, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар, үйлчилгээний журмыг нийт 256 гишүүнийг хамруулан 14 уулзалт хийж боловсруулсан.</p>
<p>1.5 Орон нутгийн бүлгүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг боловсруулах. (Q4 2018)</p>	<p>4 сумын 39 ногоочдын бүлгийн хамтарсан 7 хоршооны 2020-2021 онд хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөг бүлгүүдийн бизнес төлөвлөгөөг нэгтгэн боловсруулсан.</p>
<p>1.6 Дахин хөрөнгө оруулалтын хамтын санг байгуулах. (Q4 2018)</p>	<p>7 хоршооны дундын сангийн журмын төслийг хоршоодын тэргүүлэгчид болон хяналтын зөвлөлийн төлөөлөл 68 хүний оролцоотой бэлтгэсэн.</p>

<p>Үр дүн 2: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, тогтвортой ногооны аж ахуй эрхлэх технологи, туршлага нэвтэрсэн байна</p> <p>2.1 Хүнсний ногооны үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх (тариалалт, хог ургамлын хяналт, ургац хураалт) зорилгоор шаардлагатай тохиолдолд тариаланчдын бүлгүүдэд тариалангийн тоног төхөөрөмж, бусад багаж хэрэгслүүдийг олгох.(Q1 2019)</p>	<p>4 сумын 39 ногоочдын бүлэгт нийт 160 ш нийлэг хүлэмж (гэрээний дугаар CW-01, 2020.03 сар) болон 13 морины хүчтэй 20 ш мотоблок (гэрээний дугаар G-01, нийлүүлэгч),</p> <p>7 хоршоонд 7 ш трактор, агрегатын хамт (гэрээний дугаар G-01, 2020.03 сар) олгож, 5 ш худаг гаргаж (гэрээний дугаар CW-02, 2020.04 сар), 3,5 км цахилгааны шугам татсан. Худаг, цахилгааны шугамын өмчлөлийн асуудлыг шийдээгүй байна.</p>
<p>2.2 Хүнсний ногооны нэр төрлийг олшруулах, үнэ цэнэтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шилжих, ургалтын хугацааг уртасгах, сайжруулсан үрийн нэр төрлийг турших зорилгоор (Улаангомд) хүлэмжүүд барих.</p> <p>(Q2 – Q3, 2019)</p> <ul style="list-style-type: none"> • Хүнсний ногоо тариалах 3 суманд (Борнуур, Орхон, Ерөө) дор хаяж 72 хүлэмж; • Үр үйлдвэрлэл, туршилтын зорилгоор Увс аймагт дор хаяж 1 хүлэмж; • Төсөл хэрэгжих 1 суманд турших өвлийн 1 хүлэмж; • Хүлэмжийн үйл ажиллагаа, ус, цахилгаан ашиглалтын шилдэг туршлагауудыг танилцуулах сургалт 	<p>Улаангом сумын хүнсний ногооны үр үйлдвэрлэгчдийн 10 бүлэгт 44 ш нийлэг хүлэмж (20х6 м хүлэмж 11 ш, 4х8 м хүлэмж 33 ш) олгосон.</p> <ul style="list-style-type: none"> • Орхон, Ерөө, Борнуур сумдын 29 ногоочдын бүлэгт нийт 111 ш нийлэг хүлэмж (20х6 м 34 ш, 4х8 м 77ш) олгосон. • Улаангом дах УГТХ-ийн салбарт 5 ш 20х6 м нийлэг хүлэмж олгосон. • Ерөө суманд 500 м² өндөр технологийн, 4 улирлын хүлэмж баригдаж эхэлсэн (гэрээний дугаар CW-01, 2020.08). • Хүнсний ногооны агро-технологи, хөрс, усалгаатай тариалан болон хүлэмжинд нарийн ногоо тариалах танхимын, онлайн болон талбайн үзүүлэх сургалтууд хийж, 741 гишүүн (549)-ийг хамруулсан.
<p>2.3 Улаангом дахь үр үйлдвэрлэгч ОНТБ-ийн ус хангамж, одоогийн усалгааны системүүдийг сайжруулах. (Q1 2019)</p>	<p>Улаангом сумын хүнсний ногооны үр үйлдвэрлэгчдийн 4 бүлэгт 5 худаг гаргасан. Бүх олгосон хүлэмж өөрийн услалтын системтэй.</p> <p>Чандманийн услалтын системийн даланг засварлах ажилд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч тус төслийн хүрээнд хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн (оронд худаг гаргахаар болсон).</p>
<p>2.4 Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, тогтвортой ногооны аж ахуйн шилдэг туршлагауудын (цаг уурын өөрчлөлтөд чиглэсэн бэлэн байдал, сэлгэн тариалалт, шинэ сорт нэвтрүүлэх, органик бордоо, хортон шавж устгах бодисын хэрэглээ, ус хэмнэх шилдэг туршлагаууд г.м) талаар ОНТБ-үүдэд сургалт явуулах. (Q2 – Q4 2019)</p>	<p>Дараах сургалтууд хийгдэж, 58 гишүүн (22 эмэгтэйчүүд)-ийг хамруулсан. Үүнд:</p> <p>“Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ногоочдын чадавхийг бэхжүүлэх”, 2019.12</p>
<p>Үр дүн 3: Тариаланчид зах зээлд хүрэх боломж нэмэгдсэн байна</p> <p>3.1 Зах зээл болон нэмүү өртгийн сүлжээний судалгаа хийх.(Q1 – Q2 2018)</p>	<p>“ХХТН” ТББ-аас нэмүү өртгийн сүлжээний судалгаа хийсэн.</p>

<p>3.2 Орхон, Улаангом, Ерөө сумдад тус бүр 1 хамтын эзэмшлийн, агааржуулалттай, цаг уур, байгалийн гамшигт тэсвэртэй, өртөг багатай агуулахын байгууламжийг ОНТБ-үүдийн оролцоотой, тэдгээрийн хэрэгцээнд зориулж барих. (Q2 – Q4 2019)</p>	<p>Хүнсний ногооны зоорь барих (Орхон суманд 150 тн, Ерөө суманд 100 тн, Улаангом суманд 60 тн) зураг төслийг боловсруулах ажлыг “Амайзе” ХХК-нд гэрээлсэн (гэрээний дугаар С-08, 2020.04 сар), зураг төслийн ажил хийгдэж байна.</p>
<p>3.3 Орхонд хүнсний ногоо боловсруулах, савлах 1 цех байгуулж, турших. (Q3 2019)</p>	<p>Хүнсний ногоо дахин боловсруулах цех барих зураг төслийг боловсруулах ажлыг “Амайзе” ХХК-тай гэрээлсэн (гэрээний С-08, 2020.04 сар), зураг төслийн ажил хийгдэж байна.</p>
<p>3.4 ОНТБ-үүдийг хүнсний ногооны чанар, ангилалт, хаягдлыг устгах, хүнсний ногоо боловсруулах арга техникүүд (даршлах, нөөшлөх, зайдас хийх, хөлдөөх, шүүс гаргах г.м), бүтээгдэхүүний савлагаа, маркетингийн чиглэлээр сургаж дадлагажуулах. (Q4 2019 – Q4 2020)</p>	<p>Дараах сургалтууд хийгдэж, 409 гишүүн (247 эмэгтэйчүүд) хүнийг хамруулсан. Үүнд: “Бизнес төлөвлөгөө боловсруулах”, 2019.08 “Маркетингийн төлөвлөгөө, олон нийттэй харилцах төлөвлөгөө”, 2019.09-10</p>
<p>3.5 Төсөл хэрэгжих бүх газарт бүтээгдэхүүн борлуулах сувгуудыг бий болгож турших. (Q1 2020 – Q2 2021)</p> <p>□ Дотоодод зохион байгуулах хүнсний ногооны үзэсгэлэн худалдаануудад ОНТБ-үүдийг дэмжин оролцуулах;</p> <ul style="list-style-type: none"> • Бүтээгдэхүүн борлуулахад зориулсан 6 мухлагийг Улаанбаатар хотод байгуулж турших (төслийн сум тус бүрт 2 мухлаг); • Төсөл хэрэгжих сумдыг Улаанбаатартай холбосон автозамуудын дагуу борлуулалтын цэгүүдийг бий болгох; <p>Хүнсний ногооны аж ахуй эрхлэгч бүлгүүд болон худалдан авагчид (хөдөө аж ахуйн үйлдвэрүүд, арилжааны чиглэлийн фермүүд, супермаркет, төрийн секторын худалдан авагчид, хувь хүмүүс)-ын дунд худалдааны гэрээ байгуулж турших</p>	<p>Улаанбаатар хотод 2019 болон 2020 оны 9 сард зохион байгуулагддаг “Алтан намар” үзэсгэлэн худалдаанд 39 бүлгийн гишүүдийн ...+41,1 мянган тн ногоог борлуулж, 45,2 сая +... төгрөгийн орлого олсон.</p> <ul style="list-style-type: none"> • “Гранд авгуш” ХХК-тай гэрээ байгуулж (гэрээний дугаар СW-04, 2020.08), 6 мухлагийг барьсан боловч байрлуулах зөвшөөрөл олгогдоогүй байна. • Налайхад борлуулалтын цэг барих ажлыг мөн “Гранд авгуш” ХХК-д гэрээлсэн (гэрээний дугаар СW-04, 2020.08) боловч байршлын цэвдэгийн улмаас зураг төслийг өөрчлөх шаардлага гарсан, төслөөс гэрээний өөрчлөлтийг хийгээгүй байна.
<p>3.6 Цахим хуудас, гар утсанд суурилсан хүнсний ногооны аж ахуй эрхлэгчдийн зах зээлийн мэдээллийн сүлжээний програмыг хөгжүүлж, нэвтрүүлэх, хэрхэн ашиглахыг фермерүүд, орон нутгийн удирдлагуудад зааж сургах. (Q1 – Q2 2018)</p>	<p>Хүнсний ногоо эрхлэгчдийн зах зээлийн мэдээллийн систем боловсруулах ажлыг “Дазо” ХХК-т гэрээлэн (гэрээний дугаар G-04, 2019.05), shimtnogoo.mn цахим хуудсыг ажиллуулж, төслийн тухай, зөвлөгөө, мэдээлэл, борлуулалтын цэгийн мэдээлэл өгч, санал хүсэлт авч байна. “Дазо” ХХК мөн програм хөгжүүлэлтийг гүйцэтгэсэн, санхүүжилтийн зөвшөөрөл олгогдоогүй байна.</p>

<p>Төслийн менежментийн үйл ажиллагаа:</p> <ul style="list-style-type: none"> ТХН-ийн мэргэжилтнүүдийг шалгаруулж авах, ТХН байгуулах Жижиг дэд бүтцүүдийн судалгаа, урьдчилсан иж бүрэн судалгааг гүйцэтгэх (18 дахь сар гэхэд) Төслийн гүйцэтгэлийн менежментийн тогтолцоог ашиглан төслийн үр нөлөө, үр дагавар, үр дүнд хяналт тавих ба үнэлэх; хагас жилийн явцын тайлангуудыг хүргүүлэх, (2021 он хүртэл) Төслийн эхлэлийн (Q2 2018), дунд шатны (Q4 2019) болон эцсийн (Q2 2021) тайлангуудыг боловсруулах 	<ul style="list-style-type: none"> ТХН 2018 оны 10 сард байгуулагдсан, ТХНийн мэргэжилтнүүдийг мөн сард ажилд авсан. Төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх “ХХТН” ТББ-ыг 2019 оны 5 сард шалгаруулж, гэрээ байгуулсан (гэрээний дугаар С-01). “ХХТН” ТББ нь төсөлд хамрагдах ногоочдын судалгааг хийж, дүнг 2019 оны жилийн тайландаа тусгасан. ТХН төслийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг гүйцэтгэж, явцын улирлын тайланг монгол хэлээр бэлтгэж, ХХААХҮЯ, СЯ, хагас жилийн тайланг англи хэлээр бэлтгэж, АХБ-нд илгээсэн (нийт 7 тайлан). Эхлэлийн тайланг 2019 оны I улирал (монгол хэлээр) болон эхний хагас жил (англи хэл)-ээр бэлтгэсэн. Дунд шатны тайланг 2020 оны IV улирал болон хоёрдугаар хагаст, хаалтын тайланг 2021 оны эцэст бэлтгэнэ.
---	---

4. ТӨСЛИЙН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ, ТААМАГЛАЛ БА ЭРСДЭЛ ҮҮСЭХ МАГАДЛАЛ, ТЭДГЭЭРИЙН ТӨСӨЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх магадлалтай гэж тооцсон эрсдэлийг авч үзвэл:

Эрсдэл	Магадлал ба боломжит арга зам
Үндэсний буюу орон нутгийн улс төрийн удирдлагууд солигдсоноор хүнсний ногооны аж ахуй эрхлэх үйл ажиллагааны хэрэгжилт алдагдах	Одоогийн байдлаар энэ талаар ТББ, сумын зохицуулагчид, үр шим хүртэгчдээс мэдээлсэн зүйлгүй.
Төслийн талбай болоод эргэн тойронд онц аюултай гамшиг тохиолдох	Дээрхийн адил
Цаг хугацаанаас шалтгаалан орон нутгийн иргэдийн төслийн үйл ажиллагаанд оролцох боломж хязгаарлагдмал байх	Төслийн талаар сүүлд мэдсэн, хамрагдах сонирхолтой хүмүүс байгаа гэж мэдэгдсэн. 4 суманд байгуулагдсан хоршоодод нэгдэж, төслөөс олгогдсон дэмжлэгийн үр шимийг хүртэх боломжтой байж болно.
Орон нутгийн удирдлага, манлайллын дэмжлэг хангалтгүйн улмаас орон нутгийн салбарын буюу хөгжлийн төлөвлөгөөнд тусгах ажил хоцрогдох	Ногооны талбайд мал орох зэрэг орон нутгийн зохицуулалт шаардлагатай асуудал байгааг үр шим хүртэгчид дурдаж байсан.
Төслийн сургалтанд хамрагдсан баг, сумын удирдлагууд олноороо солигдох	Одоогоор мэдээлсэн зүйлгүй.
Чадавхижуулсан ногоочид төсөл хэрэгжсэн орон нутгаас нүүх	Одоогоор мэдээлсэн зүйлгүй.

Зоорь, хүлэмжийн байгууламжуудыг зориулалтаас гадуур ашиглах	Одоогоор мэдээлсэн зүйлгүй.
Цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас төслийн үйл ажиллагааны хэрэгжилт саатах, эсвэл төслийн дэд бүтэц эвдрэх	Хамтарсан зоорь барих газрын хөрсний чанарын улмаас зураг төслийг шинэчлэх шаардлагатай болсон, энэ ажил явагдаж байгаа.
Шинэ технологийг нэвтрүүлэх, ашиглах мэдлэг, туршлага фермерүүдэд дутмаг байх	Өвлийн хүлэмжийн технологи, агро-технологи суралцах шаардлагатай байна гэж мэдээлсэн. Мөн нийлэг хүлэмжинд анхлан ногоо тариалж байгаа гишүүдэд агро-технологийн нэмэлт сургалт шаардлагатай гэж мэдээлсэн.
Бүтээгдэхүүний маркетингийг хийх, орон нутгийн бүлгүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд эрх ашгийн сонирхолтой холбоотой эсэргүүцэл тулгарах	Одоогоор мэдээлсэн зүйлгүй.
Хүнсний ногооны үйлдвэрлэл, худалдаа, бизнесийг явуулах ур чадвар, чадавхи харилцан адилгүй байх	Энэ чиглэлээ ур чадвараа сайжруулах шаардлагатай байна гэдгээ үр шим хүртэгчид мэдээлсэн.

5. НИЙЦТЭЙ БАЙДАЛ БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Төслийн үйл ажиллагааны нийцтэй байдал ба тогтвортой байдлыг асуудал дараах байдалтай байна.

5.1. Стратегийн зорилготой нийцтэй байдал

ХХААХҮЯ-аас 2020 оны 1 сард тус төслийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийсэн тайланд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030 хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого, “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөрийн зорилттой уялдаатайгаар хэрэгжих бөгөөд төслийн үндсэн зорилго нь хүнсний ногооны үр үйлдвэрлэлийг бэхжүүлэх, хүнсний ногоо тариалагч иргэн, хуулийн этгээдийг дэмжиж, хүнсний ногооны ажлыг механикжуулах, дуслын усалгааны технологи нэвтрүүлэх, механикжсан зоорь, өвөл, зуны хүлэмжийн тоо хэмжээ, хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар дотоодын үйлдвэрлэл, хүнсний ногооны тариалалтыг дэмжиж ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад оршино” гэж заасан. Төсөл энэ хүрээнд хэрэгжиж байна.

5.2. Бодлогын орчин

Төсөл “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030 хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны 2016-2020 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлого, “Хүнсний ногоо” үндэсний хөтөлбөр болон орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүдтэй уялдаатай хэрэгжиж байна.

5.3. Эдийн засаг, санхүүгийн үндэслэл

Төсөл АХБ-ны Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа бөгөөд 2020 оны 7 сард Орхон суманд хүнсний ногоо дахин боловсруулах цех барих, 150 эмэгтэй ногоочдыг сургах зориулалтаар 0,5 сая ам. долларын нэмэлт санхүүжилт батлагдсан (ТА9348 REG: Ази, номхон далайн бүсийн эмэгтэйчүүдийн уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдлийн

нөлөөллийг бууруулах төсөл). Хүнсний ногоо дахин боловсруулах цех барих зураг төслийн ажил хийгдэж байна.

5.4. Институцийн хүчин чадал

Төслийг ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шууд удирдлагын дор ТХН болон “ХХТН” ТББ хэрэгжүүлж, 4 сумын орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүд дэмжлэг үзүүлж байна.

Төслийн хүрээнд ногоочдын бүлэг, тэдгээрээс бүрдсэн хоршоог хөгжүүлж байгаа нь төслийн зорилго, үр дүнд хүрэх, төслийн үйл ажиллагаа болон нийлүүлсэн техник, тоног төхөөрөмжийн тогтвортой, үр дүнтэй ашиглалтыг хангах зорилготой.

5.5. Нийгэм-соёлын асуудал

Төслийн хүрээнд байгуулагдсан ногоочдын бүлэг, хоршоо нь ногоочдын нийгэм, соёлын асуудлыг хамтаараа шийдвэрлэх, орон нутгийн удирдлага, шийдвэр гаргалтад нөлөөлөх, эрх ашгаа хамгаалах зэрэг зорилготой ажиллаж байна.

4 сумын 55 өрх толгойлсон эмэгтэйчүүд болон 73 орлого багатай, эмзэг бүлгийн өрхийг төслийн үйл ажиллагаанд хамруулж, тэдгээрт хүнсний ногооны үр, бордоо, хүлэмж олгон, хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Төсөл нь АХБ-ны “Хамгааллын бодлогын баримт бичиг”-т заасан сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт эсвэл газар чөлөөлөх үйл ажиллагаа эрхлэхгүй.

5.6. Оролцоо ба өмчлөл

Төслийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газраас ТХН-ийн албан өрөө, ХХААХҮЯ-ны ГТБХЗГ-ын мэргэжилтнүүдийн оролцоо зэргээр хувь нэмэр оруулж байна.

Төслийн хүрээнд байгуулагдсан 7 хоршоонд гишүүнээр элссэн ногоочид 200-500 мянга хүртэлх төгрөгийн хувь оролцоо оруулахаар шийдэж, бүрдүүлж эхэлсэн бөгөөд төслийн зүгээс тэдгээр хоршооны үйл ажиллагааг дэмжиж, дундын санд хөрөнгө оруулах төлөвлөгөөтэй, хөрөнгө оруулалтыг даруй хийж, хоршоодын үйл ажиллагааг жигдрүүлэх, бэхжүүлэх шаардлагатай байна.

Төслийн үр шим хүртэгч ногоочдын 7 хоршоо болон 39 бүлэгт олгосон трактор, худаг, цахилгааны шугам, мотоблок болон нийлэг хүлэмжийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх 3 талт гэрээний төслийг даруй хянуулж, батлуулан, гэрээ байгуулах ажлыг гүйцэтгэх шаардлагатай байна.

5.7. Жендер

Төсөл нь АХБ-ны жендерийн ангиллаар “жендерийн тэгш байдлыг хангасан” төсөл. Төслийн хэрэгжилтэд жендерийн тэгш байдлыг хангах стратеги болон жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө бэлтгэсэн. “ХХТН” ТББ-д жендерийн мэргэжилтэн ажиллаж жендерийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд нийт 18 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 1649 эмэгтэйчүүдийг хамруулж, 55 эмэгтэй тэргүүнтэй өрхөд хүлэмж, үр, бордоо олгосон.

5.8. Байгаль орчин

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу 4 суманд барих 3 механикжсан зоорь, 1 хүнсний ногооны дахин боловсруулах цехийн байгаль орчны үнэлгээг холбогдох аймгийн БОГ-аар хийлгэсэн. 2 сумын байгаль орчны байцаагчийн мэдээлснээр экологийн эмзэг орчин, усны ай сав, түүх, соёлын өв зэрэгт сөргөөр нөлөөлөх зүйл тогтоогдоогүй.

Төсөл нь АХБ-ны “Байгаль орчны хамгааллын бодлогын баримт бичиг”-ийн С ангилалд хамаарна. Иймд төслийн хүрээнд хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудад дагаж мөрдөх байгаль орчны менежментийн ерөнхий төлөвлөгөө бэлтгэж, АХБ-аар хянуулсан, түүнийг гэрээт ажил гүйцэтгэгч, төслийн оролцогч талууд болон үр шим хүртэгчид дагаж мөрдөнө.

5.9. Тохиромжит технологи

Өндөр технологийн хүлэмж: Ерөө суманд 500 м² өндөр технологийн, 4 улирлын хүлэмж барих ажил эхэлсэн. Тус хүлэмжийг оновчтой, үр ашигтай ашиглах зорилгоор 2020-2021 оны өвөл, хавар сургалт хийх, тариалалтын нарийвчилсан төлөвлөгөө гаргах шаардлагатай байна.

Төслийн зөвлөхүүд таримлын технологи, усалгааны технологийн зөвлөмжүүд өгсөн бөгөөд тэдгээрийг зохих түвшинд туршиж, тохиромжтой зүйлсийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжийг эрэлхийлэх шаардлагатай байна.

6. ХЭРЭГЖИЛТИЙН ҮР АШГИЙН ҮНЭЛГЭЭ

Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтээр үнэлбэл:

Төслийн үр дүн	Хэрэгжилт, хувиар
Үр дүн 1: Хоршоо хэлбэрээр ажиллах тариаланчдын бүлгүүд байгуулагдана	70 %
Үр дүн 2: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, тогтвортой ногооны аж ахуй эрхлэх технологи, туршлага нэвтэрсэн байна	70 %
Үр дүн 3: Тариаланчид зах зээлд хүрэх боломж нэмэгдсэн байна	70 %
дундажаар	70.0 %